

  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/249

Мандалговь

“Монтех дистрибъшн” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/216 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн ИТХ-ын ажлын албаны хэрэгцээт тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Монтех дистрибъшн” ХХК-тай 68,750,000 (жаран найман сая долоон зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Аймгийн ИТХ-ын ажлын албаны хэрэгцээт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Монтех дистрибъшн” ХХК-ний гүйцэтгэх захирал (Б.Уганболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ // Л.ДОРЖБАТ

4862111